



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/88

Булган сум

### Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хил залгаа аймаг, сумдад мал, амьтны гоц халдварт цэцэг өвчин гарсантай холбогдуулан өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өвчний тохиолдол бүртгэгдсэн (Архангай, Өвөрхангай, Төв, Дундговь аймаг) бүс нутгаас мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хязгаарласугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт, тархвар зүйн судалгааг хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, мал, амьтны шилжилт хөдөлгөөн, отор нүүдэлд тавих хяналтыг чангатган, хэрэгжилтийг ханган хамтарч ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), Цагдаагийн газар (Дэд хурандаа Г.Ганбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т, малчид, мал бүхий иргэд, бизнес эрхлэгч нарт мэдээлэл түгээж, орон нутгийн түвшинд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ